

Кодтой цоож

Фермер Жоны зүггүй үнээнүүд фермээсээ зугтсаар байв. Тэднийг фермээсээ зугтаалгахгүйн тулд тэр кодтой цоож худалдан авчээ.

Үнээнүүд ухаалаг тул Фермер Жон тэднийг хэдхэн боломж таагаад тайлагдахааргүй цоож авав.

Цоож 3 оронтой бөгөөд бүгд 1-ээс N ($1 \leq N \leq 100$) хүртэл дугаарлагдсан цикл цоож юм. Цикл гэдэг нь N болон 1 ийн тоонууд зэрэгцэж байрлана гэсэн үг юм.

Цоожийг тайлж болох 2 код байна. 1-ийг нь Фермер Жон нөгөөг нь “мэргэжилтэн” буюу цоожийг хийсэн хүний тааруулсан код байна.

Цоожинд нарийвчлалын алдаа гарсан тул тааруулсан кодны орон бүрийг ихдээ 2-оор зөрүүлэхэд цоож тайлагддаг болсон байв.

Жишээ нь:

Фермер Жоны код (1; 2; 3) харин “мэргэжилтэн”-ий код (4; 5; 6) бол (1; N; 5), (1; 1; 5), (1; 2; 5), (1; 3; 5), (1; 4; 5)...

гэх мэт оролтууд нь Фермер Жоны кодтой хангалттай ойрхон тул цоож тайлагдана. (2; 4; 8) нь “мэргэжилтэн”-ий кодтой хангалттай ойрхон

(2 + 2 = 4; 4 + 1 = 5; 8 - 2 = 6 буюу орон бүр ихдээ 2-оор зөрж байна) тул цоож тайлагдана. Харин (1; 5; 6) гэсэн оролт аль ч кодтой ойр биш тул цоож тайлагдахгүй.

Фермер Жон болон “мэргэжилтэн”-ий кодуудыг мэдэж байгаа бол цоожийг тайлж болох бүх ялгаатай утгуудын тоог ол.

Нэмэлт: (1; 2; 3) болон (3; 2; 1) нь ялгаатай гэж үзнэ.

Input

1-р мөр: Бүхэл N тоо.

2-р мөр: Зайгаар тусгаарлагдсан 3 бүхэл тоо. Энэ нь Фермер Жоны тааруулсан кодыг илтгэнэ.

3-р мөр: Зайгаар тусгаарлагдсан 3 бүхэл тоо. Энэ нь “мэргэжилтэн”-ий тааруулсан кодыг илтгэнэ.

Output

1-р мөр: Цоожийг тайлж болох бүх ялгаатай утгуудын тоо.

Example

Input:

50

1 2 3

5 6 7

Output:

249

INPUT DETAILS:

Each dial is numbered 1..50. Farmer John's combination is (1,2,3), and the master combination is (5,6,7).

Орчуулсан : УБ 1-р сургуулийн 11-р ангийн сурагч Б.Мөнх-Оргил 2019.11.15